

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР,
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны дүгээр сарын
..... -ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга /цагдаагийн хурандаа Р.Отгонжаргал/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Дэд дарга /Д.Энхсайхан/ нарт тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Журам батлах тухай” А/32, 231 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ДОТООДЫН
ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Ж.БОЛД

Т.ГАНТУЛГА

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын хэмжээнд хот суурин, хот хоорондын нийтийн эзэмшлийн зам талбай, нийтээр ашиглаж байгаа хувийн хэвшлийн болон бусад хэлбэрийн өмчлөлд багтах зам талбайд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхдээ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай, Автотээврийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг удирдлага болгоно.

1.3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх ажиллагааг хот хоорондын, ажлын байранд хүргэх тээвэрлэлт гэж ангилж ба хот хоорондын тээвэрлэлтийг энэхүү журмын 6.1 дэх хэсгийн дагуу баталсан маршрутын дагуу мөн журмын 8.1-д заасан хамгаалалттай, харин тэсрэх материалыг ажлын байранд хүргэх тээвэрлэлтийг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу тус тус гүйцэтгэнэ.

Хоёр. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюултай байдлын зэрэглэлийн ангилал

Хүснэгт №1

Хамтатгах бүлэг	Тэсрэх материалуудын ангилал ба тодорхойлолт
B	Өдөөгч тэсрэх бодис агуулсан бөгөөд хоёр хүртэл үл хамаарах хамгаалалтын төхөөрөмжтэй бүтээгдэхүүн, түүнчлэн ердийн детонатор, детонатор агуулсан хэрэгсэл, ба өдөөгч тэсрэх бодис агуулаагүй детонаторууд
C	Шидэх үйлчилгээтэй тэсрэх бодис ба бүтээгдэхүүн (утаагүй дарь)
D	Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ба шидэх үйлчилгээтэй цэнэг агуулаагүй тэсрэх бодис бүхий бүтээгдэхүүн, өдөөгч тэсрэх бодис агуулсан бөгөөд хоёр ба түүнээс дээш тооны үл хамаарах хамгаалалтын төхөөрөмжтэй бүтээгдэхүүн
E	Тэсэлгээний хэрэгсэлгүй тэсрэх бодис агуулсан, гэхдээ шидэх үйлчилгээтэй цэнэг бүхий бүтээгдэхүүн (хялбархан дөл авалцдаг шингэн, гель буюу өөрөө шатдаг шингэнээс бусад)
F	Хоёрдогч тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ба шидэх үйлчилгээтэй цэнэг агуулсан, эсвэл шидэх үйлчилгээтэй цэнэг агуулаагүй бүтээгдэхүүн
G	Пиротехникийн бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүн

N	Мэдрэмтгий чадвар нь онцгой муу тэсрэх бодис агуулсан бүтээгдэхүүн
S	Гаднын гэнэтийн үйлдлээс цочрол авч тэсрэх аюул тохиолдоход түүний үйлчилгээг хязгаарлах сав, баглаа боодолтой, хэрэв сав баглаа нь галд өртөж гэмтвэл тэсрэлтийн нөлөө цацалт нь аваар устгах, гал унтраахаар сав баглааны дэргэд хүн ажиллахад саад болохгүйгээр тусгайлан бүтээгдсэн бодис, бүтээгдэхүүн

ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН ДЭД АНГИЙН АНГИЛАЛ

Хүснэгт №2

Дэд анги	Дэд ангийн нэр
1.1	Бөөнөөр тэсрэх аюултай тэсрэх материалууд
1.2	Бөөнөөр тэсрэхгүй, гэхдээ тэсрэлтээр цацалт үүсгэх болон орчны зүйлийг гэмтээх аюултай тэсрэх материалууд
1.3	Бөөнөөр тэсрэхгүй, шатах аюултай тэсрэх материалууд
1.4	Тээвэрлэлтийн явцад гал гарах буюу өдөөсөн тохиолдолд бага зэргийн тэсрэлтийн аюултай тэсрэх материал. Тэсрэлтийн үйлчлэл нь сав баглаагаар хязгаарлагдана. Гаднын өдөөх эх үүсвэр сав баглаа дотор огцом тэсрэлт үүсгэхгүй.
1.5	Бөөнөөр тэсрэх аюултай, гэхдээ мэдрэмтгий чадвар нь маш бага, тээвэрлэлтийн хэвийн нөхцөлд өдөөлт үүсэх ёсгүй буюу шаталтаас тэсрэлтэд шилжихгүй тэсрэх материалууд
1.6	Тохиолдлын өдөөлтөд өртөх магадлал багатай, бөөнөөр тэсрэхгүй, нэн бага мэдрэх чадвартай тэсрэх бодисоор хийсэн бүтээгдэхүүн. 1.6 дэд ангийн бүтээгдэхүүний аюул нь нэг бүтээгдэхүүний тэсрэлтээр хязгаарлагдана.

Гурав. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэлтэд бэлтгэх, түүний сав, баглаа боодолд тавих шаардлага

3.1. Ачаа илгээгч нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг аюулгүй, бүрэн бүтэн, тээвэрлэхэд тохиромжтой байдлаар бэлтгэнэ. Үүнд:

3.1.1. сав, баглаа боодол, уут хайрцаг дээр үйлдвэрлэсэн, импортолсон байгууллагын нэр, хаяг, бүтээгдэхүүний нэр, энэ журмын хүснэгт 1, 2-т заасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюултай байдлын бүлгийн ангилал, дэд ангилал тус бүрийг байрлуулсан, битүүмжлэлтэй, лацадсан байх;

3.1.2. сав, баглаа боодол доторх тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь нягт чигжигдсэн, сул чөлөөтэй хөдөлгөөнгүй байх.

3.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн сав, баглаа боодол, уут хайрцгийг дараах нөхцөлд аюулгүй ачааны адил тээвэрлэхийг зөвшөөрнө. Үүнд:

3.2.1. сав, баглаа боодол, уут хайрцгийг нэг бүрчлэн шалгаад “Сав, баглаа боодол бүрэн цэвэрлэгдсэн. Аюулгүй” гэсэн тэмдэглэл хийгдсэн байх;

3.2.2. аж ахуйн нэгжийн тэмдэг, шалгасан огноотой, үзлэг хийсэн ажилтны гарын үсэгтэй байх.

Дөрөв. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавих шаардлага

4.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тусгай зориулалтаар үйлдвэрлэсэн, тоноглон шингэн түлшээр ажилладаг тээврийн хэрэгсэл болон чиргүүлээр тээвэрлэнэ. Тээврийн хэрэгслийг дараах шаардлагад нийцүүлэн тоноглон байна. Үүнд:

4.1.1.тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарч байгаа утааны яндан оч баригчтай байхаас гадна шатахууны савнаас алслагдсан байх;

4.1.2.тээврийн хэрэгслийн тэвшний хана, шал нь үрэлтээс оч үүсэхгүй галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх;

4.1.3.тээврийн хэрэгслийн шатахууны бакны хойд ба урд хэсэгт нь төмөр хаалтаар тоноглож, доод талаас нь 10x10 мм нүх бүхий төмөр тороор хамгаалсан байх бөгөөд хамгаалалт болон түлшний савны хоорондох зай 20 мм-ээс багагүй зайтай байх;

4.1.4.түлшний сав нь хөдөлгүүр, цахилгааны утаснууд, утааны яндангаас хол байрлах ба хэрвээ шатахуун гоожих тохиолдолд шууд газарт асгарахаар байрласан байх;

4.1.5.тээврийн хэрэгслийн цахилгааны тоног төхөөрөмжүүдийн хүчдэл нь 24 вольтоос ихгүй, цахилгааны хэлхээ нь гал хамгаалагчаар бүрэн хамгаалагдсан, хэлхээний бүх хүчдэлийг салгах боломжтой байдлаар тоноглон байх;

4.1.6.тээврийн хэрэгсэлд холбоо мэдээллийн хэрэгсэл шаардлагатай тохиолдолд сансрын холбооны хэрэгсэл, байршил тогтоогч GPS төхөөрөмж, тээвэрлэлтийн туршид замын видео бичлэг хийх боломжтой камер суурилуулсан байх;

4.1.7.битүүмжилсэн тэвш нь галд тэсвэртэй, бат бөх материалаар хийгдсэн, хаалга нь бат бөх, цоожлох боломжтой байх ба битүүмжилсэн тэвшний хаалга онгойсон тохиолдолд дохио өгөх систем байрлуулсан байх.

4.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

4.2.1.жолоочийн бүхээгийн дээр шар гэрэл болон тэвшний баруун, зүүн хойд талын дээд өнцөгт шар гэрэл ойлгогч байрлуулах;

4.2.2.нөөц дугуй 1-2 ширхэг, дугуйны хэмжээнд таарсан 2-оос доошгүй ивүүртэй байх;

4.2.3.ашиглалтын хугацаа дуусаагүй 5 литрээс багагүй хэмжээтэй 2-3 галын хор, гал унтраах цохиуртай байх;

4.2.4.засвар үйлчилгээ хийх иж бүрэн багаж түлхүүр, гулгалтаас хамгаалах гинжтэй байх;

4.2.5.эмийн сан, улаан гэрэл бүхий анивчих гар чийдэнтэй байх;

4.2.6.Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан “Ослын зогсолтын тэмдэг”, “Орох хориотой” тэмдэг тус бүр 2 ширхэг байх.

Тав. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолоочид тавигдах шаардлага

5.1.Тухайн ангиллын тээврийн хэрэгслийг 3-аас дээш жил тасралтгүй жолоодсон, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрмийн 16-д заасны дагуу тэсрэх материалтай харьцаж ажиллах эрх олгох сургалтад хамрагдаж, үнэмлэх авсан хүн байна.

5.2. Жолооч нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан бичиг баримтыг авч явахаас гадна дараах тээвэрлэлтийн бичиг баримттай байна. Үүнд:

5.2.1. ачаа илгээгчээс хүлээн авагчид хүлээлгэн өгөх тээврийн хэрэгслийн явах зам, хурд, хоноглох, түр зогсолт хийх, шатахуун цэнэглэх газар, ачааны нэр төрөл, тоо хэмжээ зэргийг тогтоосон тээвэрлэлт зохион байгуулалтыг төлөвлөсөн бүдүүвч зураг буюу “Тээвэрлэлтийн маршрут”;

5.2.2. тухайн тээврийн хэрэгслээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрөл;

5.2.3. тээвэрлэж яваа тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ослын карт.

5.3. Жолооч автомашины техникийн бүрэн бүтэн байдал, ачааны татлага, лац ломбо болон тэвшний хаалга хаалтуудад бүрэн хяналт тавина.

5.4. Найман цагаас дээш завсарлагагүй хугацаагаар тээвэрлэлтийн ажил гүйцэтгэх нөхцөлд ээлжийн жолоочтой байна.

5.5. Зайлшгүй зогсолт хийх тохиолдолд ачаа илгээгч болон хүлээн авагч байгууллагад шуурхай мэдэгдэж, суурин газраас 200 метрээс багагүй зайд, замын баруун гар талыг шахаж, хойно ба урдаа 100 метрийн зайд “Ослын зогсолтын тэмдэг” тавина.

5.6. Зам тээврийн осолд холбогдсон тохиолдолд жолооч Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм болон ослын картад заасны дагуу шуурхай ажиллах ба шаардлагатай гэж үзвэл дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

5.6.1. онцгой байдал болон эмнэлгийн түргэн тусламж дуудах, зам тээврийн осол, хэргийн газар руу гаднын хүмүүсийг ойртуулахгүй байх бүхий л арга хэмжээ авах;

5.6.2. ослын аюултай бүсийг тэмдэглэн зааглаж бусад хүмүүс осолд нэрвэгдэхээс сэргийлэх;

5.6.3. цагдаа, эмнэлэг болон бусад албаны ажилтнуудыг ирэх үед тээврийн баримт бичгээ шалгуулах, тээвэрлэж яваа ачааны хор хөнөөл, шинж байдлын талаар бүрэн танилцуулах.

Зургаа. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн маршрут ба тээвэрлэх хуудас

6.1. Аж ахуйн нэгж нь энэхүү журмын 5.2.1-д заасан тээвэрлэлтийн маршрутыг боловсруулан цагдаагийн байгууллагаар батлуулна. Тээвэрлэлтийн маршрутыг боловсруулахдаа дараах нөхцөлийг тооцож үйлдэнэ. Үүнд:

6.1.1. хот суурин газар, үйлдвэрийн объект, эмнэлэг, сургууль, олон нийтийн газар, байгалийн хамгаалалттай бүс, түүх соёлын дурсгалт газруудыг аль болох дайран өнгөрөхгүй байх;

6.1.2. батлагдсан хатуу хучилттай, сайжруулсан, ердийн хөрсөн замыг сонгож үйлдэх бөгөөд ямар замаар явах, хаана зогсож хоноглох, хооллох, шатахуун цэнэглэх, замын аль хэсэгт аюултай, анхааралтай явах хэсэг байгаа эсэхийг;

6.1.3. төв суурин газруудыг аль болох тойрч гарах чиглэлийг сонгох бөгөөд зайлшгүй тохиолдолд суурин газар дайрч өнгөрөх бол цувааг суурин газар орохоос өмнө хамгаалалт авах цаг хугацаа, зогсох цэг зэргийг.

6.2. Аж ахуйн нэгжээс боловсруулж илгээсэн тээвэрлэлтийн маршрутын мэдээлэл зөрүүтэй, дутуу оруулсан, даац, жин зөрүүтэй бол цагдаагийн байгууллагаас зөрчлийг арилгуулахаар татгалзаж буцаана.

6.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэх тоо хэмжээг тогтоосон “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас”-ыг мэргэжлийн хяналтын төв байгууллагаас олгох бөгөөд тээвэрлэх хуудсыг авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж нь дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

6.3.1.мэргэжлийн хяналтын төв байгууллагаас олгосон “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас”;

6.3.2.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэх тоо хэмжээг заасан албан хүсэлт;

6.3.3.цагдаагийн байгууллагаар батлуулсан “Тээвэрлэлтийн маршрут”.

6.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэх хуудас нь бичигдсэн өдрөөс эхлэн ажлын тав хоногийн дотор хүчинтэй байна.

Долоо. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн хэрэгсэлд ачих ба буулгах

7.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн хэрэгсэлд ачих, буулгахдаа зориулалтын талбайд “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

7.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн хэрэгсэлд хайрцаг савыг сул зай гаргахгүй, хоорондоо мөргөлдөхгүй, тэвшний хана, шаланд цохигдохгүй, үрэгдэхгүй, унахгүй байхаар байрлуулж ачна.

7.3.Ачаа илгээгч нь мэргэжлийн хяналтын төв байгууллагын “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас”, цагдаагийн байгууллагын баталсан “Тээвэрлэлтийн маршрут”-ыг үндэслэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олгоно.

7.4.Ачаа илгээгч нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, лац ломбо, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг нэг бүрчлэн шалгаж тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтанд хүлээлгэж өгнө.

7.5.Ачиж буулгах үйл ажиллагаа нь тухайн аж ахуйн нэгжийн мөрддөг аюулгүй ажиллагааны зааврын дагуу явагдана. Ачаа ачуулсан машин үйлдвэр-агуулахын талбайгаас гарч тусгай зориулалтын хамгаалалттай талбайд байрлана. Ачаа ачуулах дараагийн машин ачилт, буулгалтын талбайгаас 100 метрээс хол зайд байрлаж хүлээнэ.

7.6.Ачаа ачиж буулгах үед жолооч нь тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг унтрааж, зогсоолын тормоз татаж, хоёр талын дугуйнд ивүүр хийн, бүхээгээс бууж, аюулгүй байдлыг хангана.

7.7.Ачааг хоёр болон түүнээс дээш хүлээн авагчид нэг удаагийн тээвэрлэлтээр хүргэх бол тэдгээрийг зааглан бэхэлж, тус тусад нь ачиж буулгана.

Найм. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед тавих шаардлага

8.1.Тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан, дотоодын цэргийн алба хаагч /цаашид “хамгаалалтын ажилтан” гэх/, жолооч нар ачааныхаа шинж байдал онцлог нөхцөл байдлыг мэдсэн байх шаардлагатайгаас гадна болзошгүй ослын үед хувийн хамгаалах хэрэгслүүдийг ашиглах, анхны тусламж үзүүлэх чадвартай байна.

8.2.Тээврийн хэрэгсэл нь ачилт, буулгалт, тээвэрлэлтийн явцад хамгаалалтын ажилтан болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан, жолоочийн байнгын хараа хяналтад байх ба цуваагаар тээвэрлээгүй тохиолдолд жолооч нь тээвэрлэлтийн үйл ажиллагааг хариуцсан ажилтны үүргийг давхар гүйцэтгэж болно.

8.3.Нэг тээврийн хэрэгслээр тээвэрлэж яваа нөхцөлд тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан болон хамгаалалтын ажилтан нар хамт явж болох бөгөөд хоёр, түүнээс дээш тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа үед тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан урд талын машинд, хамгаалалтын ажилтан сүүлийн автомашинд явж, хоорондоо холбогдох холбооны хэрэгсэлтэй байна.

8.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл нь шатахуунаар хүрэлцэхүйц цэнэглэгдсэн байна. Зайлшгүй шаардлагаар зам зуур шатахуунаар цэнэглэх нөхцөлд хот, суурин газрын захад байрласан маршрутад тусгагдсан шатахуун түгээх станцаас цэнэглэж болно.

8.5.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийн хурдыг хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгсэл болон тээж яваа ачааны онцлог, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр тохируулан сонгож явна.

8.6.Тав болон түүнээс илүү тооны автомашинууд цуваагаар тээвэрлэх тохиолдолд цувааны урд заавал хамгаалалтын хөтөч автомашин, цувааны сүүлд нөөц тээврийн хэрэгсэл заавал явна. Хамгаалалтын хөтөч автомашин болон цуваанд яваа тээврийн хэрэгслүүд нь ойрын гэрлээ асааж явна.

8.7.Аянга цахилгаантай бороотой үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсооно. Ингэхдээ тээврийн хэрэгслийг ой мод болон хот суурин газраас 200 метр, машин хооронд 50 метрээс багагүй зайд байрлуулж, жолооч болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан, хамгаалалтын ажилтнууд нь тээврийн хэрэгслийг 200 метрээс багагүй зайнаас хянана.

8.8.Тээврийн хэрэгслийн хойно ба урд талд тэсрэх материалын ангилал, дэд ангилал, НҮБ-ын аюултай ачааны код бүхий “Аюултай ачаа тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл” таних тэмдгийг Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3 дугаар хавсралтад заагдсаны дагуу байрлуулна.

8.9.“Аюултай ачаа тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл” таних тэмдгийг тээврийн хэрэгсэл дээр тусгай тогтоогч дээр бэхлэн байрлуулах ба тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлээгүй үед уг тэмдгийг авах, эсхүл далдалж замын хөдөлгөөнд оролцоно.

8.10.Тээвэрлэлтийн үед давагдашгүй хүчин зүйл тохиолдож цаг агаар, замын нөхцөл байдлаас шалтгаалж тухайн маршрутад заасан замаар тээвэрлэлтийг цааш үргэлжлүүлэх боломжгүй болвол ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, дотоодын цэрэг, цагдаагийн байгууллагын холбогдох ажилтнуудын зөвшилцсөнөөр саад, бэрхшээлийг тойрон явж болно.

Ес. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн ослын карт

9.1.Тээвэрлэлтийн үед тээвэрлэж буй ачааны онцлог шинж чанар, хор хөнөөлт байдал, тээвэрлэлтийн явцад тохиолдож болох эрсдэл, аюул ослын үед авах хариу арга хэмжээ, шаардлагатай үед тусламж дуудах утасны дугааруудыг тусгасан мэдээлэх хуудас /маягт №2/ бүхий тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн ослын карт /цаашид “Ослын карт” гэх/-тай байна.

9.2.Ослын картыг ачаа илгээгч байгууллага бөглөж ачааны зарлагын баримттай хамт тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан болон тээврийн хэрэгслийн жолоочид хүлээлгэн өгнө.

9.3.Ослын карт дээрх яаралтай арга хэмжээ авах тоон кодууд нь НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан зааварт заасны дагуу тавина.

9.4.Тээвэрлэлтийн үед осол гарсан тохиолдолд ослын картад заасан хариу арга хэмжээнүүдийг яаралтай авч хэрэгжүүлнэ.

Арав. Зөвшөөрөл олгох

10.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл хүсэхдээ дараах бичиг баримтыг цагдаагийн төв байгууллагын бүртгэл хяналтын ажил хариуцсан нэгжид ирүүлнэ. Үүнд:

10.1.1.зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн албан бичиг;

10.1.2.аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

10.1.3.аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулбар;

10.1.4.жолоочийн үнэмлэх, тэсрэх материалтай харьцаж ажиллах эрхийн үнэмлэх;

10.1.5.тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар;

10.1.6.тээврийн хэрэгслийг стандартын дагуу тусгайлан тоногловсон тухай аж ахуйн нэгжийн тодорхойлолт, уг тээврийн хэрэгслийг 4 талаас нь авсан фото зураг;

10.1.7.тээврийн хэрэгслийн оношилгооны дүгнэлтийн хуудас.

10.2.Цагдаагийн төв байгууллагын бүртгэл хяналтын ажил хариуцсан нэгж нь аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, энэхүү журмын 10.1-д заасан бичиг баримтыг хангасан тохиолдолд ажлын 10 хоногт багтаан зөвшөөрөл /маягт №1/-ийг олгоно.

10.3.Тээврийн хэрэгслийн зөвшөөрөл нь 6-12 сарын хугацаатай ба тухайн тээврийн хэрэгслийн гэрчилгээний хамт хүчинтэй байна.

Арван нэг. Хориглох зүйл

11.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах зүйлийг хориглоно. Үүнд:

11.1.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг өөрөө буулгагч тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

11.1.2.тусгайлан тоноглогдоогүй, зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх;

11.1.3.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх үед тээврийн хэрэгслээс 100 метрээс ойр зайд тамхи татах, ил гал гаргах;

11.1.4.тусгай зориулалтын хатуу холбоогоор холбогдоогүй чиргүүлээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх;

11.1.5.жолооч нь энэхүү журмын 8.10-д заагдсан нөхцөлөөс бусад тохиолдолд батлагдсан маршрутыг зөрчих, өөр газарт зогсолт хийх, хурд хэтрүүлэх;

11.1.6.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэлд өөр төрлийн ачаа ачих, уг ачаатай хамааралгүй хүн авч явах;

11.1.7.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийг цахилгаан дамжуулах шугамын доор, гүүрний дээр болон доор, туннель дотор, суурин газар зогсох болон гараж түүнтэй адилтгах барилга байгууламж дотор тавих;

11.1.8.амархан шатах материалаар хийгдсэн татлага буюу хучлагыг хэрэглэх.

Арван хоёр. Бусад

12.1.Тээвэрлэлтийн маршрут батлах, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас олгох, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох талаар бүртгэлийн сан хөтөлж, тухай бүр баяжилт хийнэ.

12.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журмыг зөрчсөн, эсхүл хуурамч бичиг баримт бүрдүүлэн зөвшөөрөл авсан тохиолдолд аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ ТЭЭВЭРЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ОЛГОХ ЗӨВШӨӨРӨЛ

<p style="text-align: center;">САНАМЖ</p> <p>Тэсэрч дэлбэрэх бодисыг тэсэлгээний хэрэгсэл, харгалзан хүргэх харуул, тээвэрлэлтийн үйл ажиллагааг хариуцсан ахлагч нарыг хамт тээвэрлэхийг хориглоно.</p> <p>ШААРДЛАГАТАЙ УТАСНЫ ЖАГСААЛТ:</p> <p>Онцгой байдал - 101 Цагдаа - 102 Тургэн тусламж - 103 Аврах бүлэг - 105 ЦЕГ-ын ШУШтаб - 91235040 Лицензийн төв - 93200100</p>	 <p>МОНГОЛ УЛС ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР STATE POLICE DEPARTMENT</p> <p>ЗӨВШӨӨРЛИЙН ҮНЭМЛЭХ License of permission</p>	<p>Монгол улсын тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйл</p> <p>14.2 Тэсэрч дэлбэрэх бодисыг тэсэлгээний хэрэгслийн хамт тээвэрлэхийг хориглоно.</p> <p>14.3 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх зааварчилгааг тээврийн хэрэгслийн жолооч болон дагалдан яваа хүн бүрд танилцуулж, аюулгүй байдлыг хангасан байна.</p> <p>14.4 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хот, тосгон, бусад суурин газраар тээвэрлэхдээ онц аюултай ачаа тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааны техникийн шаардлагыг хангасан байна.</p>	<p style="text-align: center;">ЗӨВШӨӨРӨЛ №15/1-01 / License number /</p> <p>"Автотээврийн тухай", "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай", хууль, "Замын хөдөлгөөний дүрэм", "Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 188 тоот тушаал", "Аюултай ачаа MNS 4978:2000", "Өвөр ихтэй ачаа" MNS MNS 5345:2011 стандарт, хууль, дүрмийг үндэслэн:</p> <p>..... овогтой "....." ангилалтай дугаарын үнэмлэхтэй маркийн улсын дугаартай тээврийн хэрэгслээр 201... оны дугаар сарыннаас 201... оны дугаар сарынны хооронд "ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ"-г тээвэрлэх зөвшөөрөл олгов.</p> <p style="text-align: right;">ДАРГА ЦАГДААГИЙН ХУРАНДААГ ЭРДЭНЭЦАЦРАЛ</p>
--	--	--	--



ОСЛЫН КАРТ

НҮБ-ИЙН ДУГААР	АЧААНЫ ТӨРӨЛ, НЭРШИЛ	АЮУЛЫН ЗЭРЭГЛЭЛ	ШУУРХАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ КОД
ҮНДСЭН ШИНЖ ЧАНАР БА АЮУЛЫН ЗЭРЭГЛЭЛ			
Үндсэн шинж чанар	Тухайн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн шинж чанарыг тодорхой бичих		
Галын болон тэсрэлтийн аюул	Тэсрэлт болон галын аюулаас байгаль орчинд үзүүлэх, хүнд учрах хор хөнөөлийн талаар тодорхой бичих		
Хүний эрүүл мэндэд аюултай байдал			
Яаралтай үед холбоо барих утас			
ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ			
Хамгаалах хэрэгслүүд зайлшгүй байх талаар бичих			
ОСЛЫН НӨХЦӨЛД ЗАЙЛШГҮЙ АВАХ АРГА ХЭМЖЭЭ			
Тээвэрлэлтийн үед			
Гал түймрийн үед			
ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН АРГА ХЭМЖЭЭНҮҮД			

Тайлбар: Ослын картыг бөглөхдөө тухайн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн техникийн тодорхойлолт, ашиглалтын заавруудаас авч бичнэ.